НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

| Д/д | | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /сая төгрөг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн Хувь | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1 ДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ (23 Зорилт 85 арга хэмжээ)** | | | | | | | | | |
| **1.1. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗААЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО (7 Зорилт 14 арга хэмжээ)** | | | | | | | | | |
| 1.1 | | **Зорилт 1.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.** (МУХТЖҮЧ 2.2.8 НХТЖҮЧ 2.11.1 НЗДҮАХ 2.1. ДЗДҮАХ 1.1) | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90 | 90 | Нийт 36 удаагийн сургалтад давхардсан тоогоор 62 эмч, эмнэлгийн ажилтныг хамруулж мэдлэг, ур чадварыг дээшлүүлэв. Мэргэжил дээшлүүлэх сургалтад 3 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдаж байна. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэгт 8722 иргэн хамрагдаж 44,4 хувьтай байна. | 86,6 | 70 |
| 1. | 1.1.1 | | Сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн ажилтан | 144 | 100 | 60 | Эмч, эмнэлгийн ажилтны мэдлэг ур чадварыг дээшлүүлэх дотоодын сургалтыг 8 удаа зохион байгуулж 17, ЭМЯ, НЭМГ, НЭМҮТ-өөс зохион байгуулсан 27 удаагийн сургалтад давхардсан тоогоор 44 эмч, эмнэлгийн ажилтныг хамруулав. Тайлангийн хугацаанд байнгын ажлын байраар 5, түр ажлын байр 1, гэрээгээр 2 эмч, эмнэлгийн ажилтныг томилон ажиллуулав. Мэргэжил дээшлүүлэх сургалтад сувилагч 2, эм найруулагчаар 1 нийт 3 ажилтан, албан хаагч суралцаж байгаагаас гадна БНХАУ-ын Хөх хотод | 100 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2025 оны 05 дугаар сард зохион байгуулагдсан мэргэжил дээшлүүлэх сургалтад 1 эмчийг хамруулав. | | |
| 2. | 1.1.2 | 64,0 | Хангагдсан тоног төхөөрөмжийн тоо | 18 | 1 | 3 | “Түншлэл-Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх” зорилтот жилийн хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн Эрүүл мэндийн төвийн сүрлэн барилгыг “Сэргээн засах үйлчилгээ” үзүүлэх зориулалтаар ажиллуулахаар бэлтгэл ажлыг хангаң шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл авахаар үнийн саналыг судалж байна.<br>ЭМЯ-аас 2025 оны 06 дугаар сард гар ЭКГ, даралтын монитор зэрэг 2 нэр төрлийн 4 ширхэг тоног төхөөрөмжөөр хангав. | 90 | 90 |
| 3. | 1.1.3 | | Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт хамрагдалтын хувь | 70,1 | 70 | 70 | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 03 дугаар тогтоолоор дүүргийн Эрүүл мэндийн төв нь хүн амын тооноос шалтгаалан “Анхан шатны тусламж үйлчилгээ”-рүү шилжсэнтэй холбогдуулан эрт илрүүлэг үзлэгт 0-18 насны хүүхдийг хамруулах боломжтой байгаа ба насанд хүрэгчдэд үзлэг хийх эрх нээлгэх саналыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хүргүүлээд байна.<br>Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт 2025 оны хагас жилийн байдлаар 8722 иргэн хамрагдаж 44,4%, артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт 2822 хүн хамрагдахаас 425 хамрагдаж 15%, Чихрийн шижин хэв шинж-2 үзлэгт 1728 хүн хамрагдахаас 395 иргэн хамрагдаж 22,8%, Умайн хүзүүний эрт илрүүлгийн үзлэгт 276 хүн хамрагдахаас 61 хамрагдаж 22%-тай байна. | 70 | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ЭМТ, Монголын Сүрьеэгийн нийгэмлэгтэй хамтран сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж нийт 114 иргэнийг хамруулснаас 21 иргэнээс сорьц авч ХӨСҮТ-д онош тодруулах шинжилгээнд хамруулаа. | | |
| 1.2 | | **Зорилт 1.2 Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх** (МУХТЖҮЧ 3.5.3 ЗГҮАХ 2.1.4 НХТЖҮЧ 3.5.3 НЗДҮАХ 2.1.7 ДЗДҮАХ 1.2.) | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90 | 90 | Дүүргийн БТСХороо нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр 10 заалт бүхий төлөвлөгөө гарган улс бүс, дүүргийн чанартай 12 төрлийн тэмцээн зохион байгуулж давхардсан тоогоор 103 байгууллагын 5725 ажилтан албан хаагч, иргэд оролцож 29,9 сая төгрөг зарцуулав. | 90 | 90 |
| 4. | 1.2.1 | Арга хэмжээ: Иргэдийг нийтийн биеийн тамир спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангах | | Дугуйлан секцэд хамрагдсан хүний тоо | 83 | 100 | БТСХ нь иргэдийг биеийн тамир спортоор хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлж 8 ААНБ-тай гэрээ байгуулж 7 хоног бүр 2 цаг спорт заалаар үйлчилж байна. "Дасгал хийж хамтдаа хөгжье", "Ажлын байрны дасгал", "Эрүүл Монгол" өглөөний дасгал зэрэг 5 аян өрнүүлж давхардсан тоогоор 71 байгууллагын 4250 ажилтан, албан хаагч, иргэд оролцов. Мэргэжлийн спортын 12 холбоотой хамтран "Өвлийн өдөрлөг-Мөсний сурын харваа", "Багахангай лиг-2025", "Багахангай Марафон-2025" Улсын аварга шалгаруулах тэмцээн, Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн нэрэмжит "Мини волейбол"-ын U11, U12 насны тэмцээн зэрэг улс, нийслэл, бүсийн чанартай 7 тэмцээн зохион байгуулж давхардсан тоогоор 1465 тамирчин оролцож 29,9 сая төгрөг зарцуулав. Сагсан бөмбөг, Волейбол, Шагайн харваа, Чөлөөт бөх, Жудо бөх, | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Таеквондо гэсэн 6 төрлөөр секц, дугуйлан хичээллэж байгаа ба давхардсан тоогоор 90 өсвөрийн тамирчид хичээллэж байна. Таеквондо, Чөлөөт бөхийн 2025 оны Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон 2 дасгалжуулагч, 10 тамирчныг “Онцгой амжилт гаргасан багш, сурагчдыг шагнах журам”-ын дагуу шагнаж урамшуулав. Чөлөөт бөхийн Азийн аварга шалгаруулах тэмцээнд Улсаа төлөөлөн оролцох багш А.Даваажаргалын замын зардалд дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээнд 6,4 сая төгрөг зарцуулав. | | |
| 5. | 1.2.2 | Арга хэмжээ:<br>Иргэдэд үйлчлэх биеийн тамир, спортын стандартын шаардлага хангасан зал, талбайн хэмжээг нэмэгдүүлэх | - | 2-р хорооны заалийг ашиглалтад оруулах | 90 | 100 | Дүүргийн хэмжээнд БТСХороо 1, ЕБС-ийн 2 нийт 3 заал, Сагсан бөмбөгийн 3х3 талбай 2, сагсан бөмбөг болон волейболын 5 талбайг ашиглаж байна.<br>Дүүргийн 2 дугаар хорооны “Спорт цогцолбор”-ын барилгыг 06 дугаар сарын 30-ны өдөр ашиглалтад хүлээн авахаар төлөвлөөд байгаа ба барилгын явц 85 хувьтай байна. НОНХС-ийн хөрөнгө оруулалтаар Ерөнхий боловсролын сургуулийн 94 дүгээр сургуулийн спорт заалны шал, дээврийн засварыг 113,1 сая төгрөгөөр засварлахаар гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулав. | 90 | 90 |
| 1.3 | | **Зорилт 1.3** Боловсролын байгууллагын чанар хүртээмжийг нэмэгдүүлэн, сургалтын таатай орчныг бүрдүүлнэ. (МУХТЖҮЧ 2.1.8<br>ЗГҮАХ 2.2.1<br>НХТЖҮЧ 2.2.1 | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90 | 90 | Дүүргийн хэмжээнд 2025 онд боловсролын байгууллагын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулах ажил, арга хэмжээний төлөвлөгөөг 14 заалттайгаар боловсруулав. Боловсролын байгууллагуудын сургалтын таатай орчныг бүрдүүлэхэд 545,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, 72 багшийн ур чадварыг нэмэгдүүлэх, | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | НЗДҮАХ 2.2<br>ДЗДҮАХ 1.3) | | | | | чадавхжуулах сургалтад хамруулав. | | |
| 6. | 2.3.1 | Арга хэмжээ:<br>Багшийн ур чадварын түвшинг дээшлүүлнэ. | | Сургалтад хамрагдсан багш | 129 | 100 | Багшийн ур чадвар дээшлүүлэх танхимын сургалтад 42, цахим сургалтад 21 багш хамрагдав.<br>2024-2025 оны хичээлийн жилд 1,5,10 дахь жилдээ ажиллаж байгаа 9 багш үндсэн сургалтад хамрагдсан байна.<br>Байгууллага болон багшийн ажлыг гүйцэтгэл үр дүнгээр үнэлэх ажлын хүрээнд 2024-2025 оны СӨББ-ын багшийн гүйцэтгэлийн үнэлгээ 04 дүгээр сарын 28-наас 05 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулагдаж төрийн өмчийн 2 цэцэрлэгийн 8 багш, 8 бүлгийн 136 хүүхэд, ЕБС-н гүйцэтгэлийн үнэлгээ 05 дугаар сарын 12-23-ны өдрүүдэд зохион байгуулагдаж төрийн өмчийн 2 сургуулийн 34 багш, 34 бүлгийн 806 сурагч хамрагдав.<br>Өмнөх жилийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд тулгуурлан “Суралцагчид боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааны үр дүнгийн ахиц, үр дүн”, “Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих”, “Удирдлагын манлайлал менежмент”, “Сургалтын орчин бүрдүүлэлт”, “Эцэг эх сурагчийн сэтгэл ханамж” зэрэг 9 чиглэлээр арга хэмжээ зохион байгуулав. Боловсролын хэлтэс, 207-р цэцэрлэг хамтран зүүн бүсийн 3 дүүргийн СӨББ-ын “Багшийн мэргэжлийн хөгжлийн бүлэг-”ийн гишүүдэд “Тоглоом, зохиол сонирхон судлах арга зүй” узүүлэх сургалтыг зохион байгуулав. Уг сургалтад 23 багш хамрагдав. | 90 | 90 |
| 7. | 2.3.2 | Арга хэмжээ:<br>Хүүхэд багачуудын сурч | | Хүүхдийн хамрагдалт | 978 | 900 | Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Ерөнхий | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | боловсрох таатай орчин, өөрийгөө нээн хөгжүүлэх боломж нөхцлийг бүрдүүлнэ | | | | | боловсролын 94 дүгээр сургуулийн спорт заалны шал болон дээврийн засвар, 91 дүгээр сургуулийн дотор засварыг 433,1 сая, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар боловсролын байгууллагуудад ухаалаг самбар нийлүүлэх ажлыг 112,0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээг байгуулав.<br>Дүүргийн Насан туршийн суралцахуйн төв нь 2025 оны 01 сарын 01-ний өдрөөс бие даасан төв болон үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд тусгай хэрэгцээт хүүхдийн сурч хөгжих, бие даан амьдрах чадвар олгоход хүртээмжтэй, таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2025 оны А/73 дугаар захирамжаар 1,6 сая төгрөгийн өртгөөр 1 танхимыг тохижуулж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангав<br>Ерөнхий боловсролын 91, 94 дүгээр сургуулийн цайны газрыг засварлаж Үдийн хоол хөтөлбөрт 439 сурагч хамрагдав.<br>Хүүхэд багачуудын өөрийгөө нээн хөгжүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор СӨББ-ууд 11 төрлийн дугуйлан хичээллүүлж 182, ЕБС-ууд 16 төрлийн дугуйлан хичээллүүлж 334 сурагч хамрагдаж байна. | | |
| 1.4 | | **Зорилт 1.4**<br>Нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.<br>(ЗГҮАХ 2.1.3.9 НХТЖҮЧ 3.1.1, 3.2.1, НЗДҮАХ 2.3.1, 2.3.2 ДЗДҮАХ 1.4.) | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90 | 90 | Тайлангийн хугацаанд дүүргийн ХХҮХ нь нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтөд 2890 иргэнийг хамруулан 1,6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. | 100 | 90 |
| 8. | 1.4.1 | Арга хэмжээ: | 60,0 | Хамрагдсан | 3564 | 3000 | Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 1643 | 100 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дүүргийн хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээт (хөгжлийн бэрхшээлтэй) болон амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх | | хүний тоо | | | хүүхдэд олгож 976,3 сая, ахмад болон алдар цолтон ахмад настны дэмжлэг, тусламж, хөнгөлөлтөд 44 иргэнийг хамруулж 10,4 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжид 12 иргэнийг хамруулж 4,3 сая төгрөгийг тус тус зарцуулав.Нийтийн тээврээр хөнгөлөлттэй үнээр зорчих картыг хөгжлийн бэрхшээлтэй 12 иргэнд шинээр олгож 7 иргэнд сунгалт, ахмад настны сунгалт 14, шинээр 52 карт тус тус олгов.<br>2025 оны эхний хагас жилийн байдлаар хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 21 өрхийн 110 иргэнийг хамруулан 7,1 сая төгрөг зарцуулсан байна. | | |
| 1.5 | | **Зорилт 1.5**<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин зорилтот бүлгийн иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлнэ. (ЗГҮАХ 2.1.2.3, НХТЖҮЧ 3.4.1, 2.15.3, НЗДҮАХ 2.3.3, 2.3.4, 2.3.7<br>ДЗДҮАХ 1.5.) | | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 90 | 90 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгодог санхүүгийн дэмжлэгт 9 иргэний 93,0 сая төгрөгийн төслийг шалгаруулан гэрээ байгуулаад байна. | 80 | 70 |
| 9. | 1.5.1 | Арга хэмжээ:<br>Зорилтот бүлгийн иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх | - | Хамрагдсан иргэдийн тоо | 8 | 10 | 2025 оны 4 дүгээр сард хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн 5 иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, суурь ур чадвар олгох сургалтад хамруулав.<br>Тус үйлчилгээнд хамрагдаж буй хөдөлмөрийн насны, хөдөлмөрлөх чадвартай ажилгүй иргэнтэй 19 өрхөд ажлын байрны зар мэдээг 9 удаа хүргэж 1 иргэнийг байнгын ажлын байранд зуучиллаа.Түр ажлын байраар хангах үйл ажиллагааны хүрээнд ХХҮХ | 90 | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хороодтой хамтран мод тарих 8 хоногийн ажилд зорилтот бүлгийн 11 иргэнийг хамруулаад байна. | | |
| 10. | 1.5.2 | Арга хэмжээ: Ахмад настны мэргэжлийн ур чадвар, ажлын туршлагад суурилсан зөвлөн туслах, үйлчилгээнд хамрагдагсдын тоог нэмэгдүүлэх | - | Хамрагдсан ахмад настны тоо | 4 | 5 | 2025 онд зарцуулах төсвийн хуваарилалт удаашралсантай холбогдуулан ахмад настны зөвлөн туслах үйлчилгээг 9-12 сард зохион байгуулахаар болоод байна. Ахмадын санхүүгийн эргэн төлөгдөх дэмжлэгээс 3 ахмад настанд 23,0 сая төгрөг олгов. | 70 | 30 |
| 1.6 | | **Зорилт 1.6** Соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. (ЗГҮАХ 3.3.6.3, 3.3.6.13 НЗДҮАХ 2.4.1, НХТЖҮЧ 1.1.1, 1.2.1 ДЗДҮАХ 1.6) | | Үйл ажиллагаа ы хэрэгжилт, хувь | 90 | 90 | Тайлангийн хугацаанд урлагийн тоглолт 4, хурал цуглаан боловсролын хөтөлбөр 48, соёл олон нийтийн ажил 6, кино үзвэр 4, номын сангаар 198 иргэн үйлчлүүлж нийт 935 соёл урлагийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 4010 иргэн хамрагдсан байна. | 90 | 90 |
| 11. | 1.6.1 | Арга хэмжээ: Хүүхэд залуучууд, иргэдийг хотын соёлд суралцуулах мэргэжлийн байгууллагатай хамтран соёлын олон талт арга хэмжээг зохион байгуулна. | - | Хамтран ажилласан байгууллага<br><br>Зохион байгуулсан арга хэмжээ | 4<br><br>4 | 3<br><br>3 | Дүүргийн хэмжээнд 2025 онд зохион байгуулах соёлын төлөвлөгөөг 9 заалттай боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллав. Хүүхэд, залуучууд, иргэдийг хотын соёлд суралцуулах, соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд соёлын ордны үндэсний хөгжмийн дугуйлангийн сурагчдын “Үл тасрах аялгуу”, “Цэндийн аялгуу”, Улаанбаатар театр болон ЦЕГ-ын Сүлд чуулгын тоглолт, “Ахмадаа сонсъё” арга хэмжээнд Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын гоцлол дуучид болон Соёлын ордны уран бүтээлчдийн тоглолтыг тус тус зохион байгуулаад байна. Иргэд, хүүхэд багачуудыг хотын соёлд суралцуулах, соёлыг түгээн дэлгэрүүлэх соёлтой, хариуцлагатай иргэн байхыг уриалсан 6 шторк бэлтгэн | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | цахим сүлжээнд байршуулж 2100 иргэний хандалт авав. | | |
| 1.7 | | **Зорилт 1.7**<br>Гэр бүлийн тогтвортой байдлыг хангана. (МУХТЖҮЧ 2.3.4<br>ЗГҮАХ 2.1.1.4,<br>НХТЖҮЧ 3.3.4, 2.12.1, 2.14.1,<br>НЗДҮАХ 2.5,<br>ДЗДҮАХ 1.7) | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90 | 90 | Гэр бүлийн чуулга уулзалт, өдөрлөг 2, гэр бүлийн боловсрол олгох сургалтыг 7, хүүхдийн хүмүүжлийн зөрэг арга сургалтыг 2 удаа зохион байгуулж 640 иргэнийг хамруулав. | 90 | 90 |
| 12. | 1.7.1 | Арга хэмжээ:<br>Гэр бүлийн гишүүн бүрт чиглэсэн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулж, гэр бүлд үзүүлэх хамгааллын үйлчилгээг сайжруулна. | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br><br>Хамрагдсан хүний тоо | 28<br><br>1553 | 10<br><br>500 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/122 тоот тушаалаар батлагдсан Гэр бүлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийн бүтэц, 8 агуулгын хүрээнд 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор 430, дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшил, худалдаа, үйлчилгээний 9 байгууллагын 120 иргэнийг хамруулж цахим мэдээллийн хэрэгслүүдээр 3 шторк, 6 төрлийн мэдээ мэдээллийг байршуулан 2759 хандалт авав.<br>Хагас жилийн байдлаар хүүхэд, гэр бүлийн хамгааллын үйлчилгээ авсан, авч буй 23 тохиолдлын 23 хүүхэд, 7 иргэнд нөхцөл байдлын үнэлгээ хийж хамгааллын үйлчилгээг хууль тогтоомжийн хүрээнд хүргэж, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 2-11 насны 5 эмэгтэй, 1 эрэгтэй хүүхэд, 28-37 настай 2 эмэгтэй хохирогчийн аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байранд хүлээн авч үйлчилгээ үзүүлэв.<br>Тайлангийн хугацаанд 10 хувийн хэргийг хаасан ба 13 кейс хяналтад байна.<br>Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлд үйлчилгээ үзүүлэх зорилгоор сэтгэл зүйч, хуульч, өмгөөлөгч, зөвлөх, | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургагч багштай гэрээ байгуулан зөвлөх үйлчилгээ, сургалтын арга хэмжээг зохион байгуулж 20 хүнд 70,5 цагийн ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг үзүүлэв. | | |
| 13. | 1.7.2 | Арга хэмжээ: “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” дүүргийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулна. | | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 96% | 95 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах 2025 оны төлөвлөгөөг 4 бүлэг 34 заалттай боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллав. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг аж ахуйн нэгж байгууллага, олон нийтэд таниулах, сурталчлах, хэвшмэл ойлголт хандлагыг өөрчлөх зорилгоор “Харилцан хүндэтгэе” аяны хүрээнд 6 сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 306 иргэн, 267 хүүхэд хамрагдсан бөгөөд цахимаар 5 төрлийн мэдээллийг түгээн 500 хандалт авав. “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-т хөндлөнгийн үнэлгээ хийлгэхээр дүүргийн 2025 оны төсөвт 3,0 сая төгрөгийг тусгуулсан ба одоогоор хөндлөнгийн хяналт, шинжилгээ үнэлгээ хийх төрийн бус байгууллагуудын саналыг хүлээн авч байна.<br>Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулж буй “Ментор менторшил” хөтөлбөрт хамрагдан дүүрэгт ажиллах ментортой хамтран дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг хүйсээр ангилсан судалгааны ажил явуулахаар судалгааг нэгтгэж байна.<br>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр танхим болон цахимаар зохион байгуулагдсан 6 төрлийн сургалтад давхардсан тоогоор 43 ажилтан албан хаагч хамрагдав. | 90 | 70 |
| 14. | 1.7.3 | Арга хэмжээ: | - | Зохион | - | 4 | “Түншлэл-Үйлчилгээний соёл”-ыг | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах олон талт арга хэмжээ зохион байгуулна | | байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан хүний тоо | | 100 | дээшлүүлэх зорилтот жилийн хүрээнд иргэдийн санал хүсэлтийг сонсох, дүүрэг орон нутгаас баримталж буй бодлого шийдвэр, зохион байгуулж буй ажил арга хэмжээг танилцуулах ажлыг зохион байгуулж байна. Их дээд сургуульд суралцаж буй оюутан залуустай уулзах уулзалтыг дүүргийн Засаг даргын 2025 оны А/53 дугаар захирамжийн дагуу 2025 оны 3 дугаар сард Чингис хаан үндэсний музейд зохион байгуулав. Уг уулзалтад 56 оюутан хамрагдаж Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,076,180 төгрөг зарцуулав.<br>Залуу гэр бүлийн үнэт зүйлсийг таниулах, харилцааг бэхжүүлэх, хүүхэд хамгаалалд гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор залуу гэр бүлийн чуулганыг "Хүүхэд–Хайр–Ирээдүй" уриан дор 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгууллаа. Арга хэмжээнд 35 залуу гэр бүл 70 иргэн хамрагдаж чуулганаас гарсан уриалга, мэдээллийг олон нийтэд түгээн 1982 хүний хандалт авав. | | |
| **ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР** | | | | | | | | | |
| **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО ( 7 зорилт 13 арга хэмжээ)** | | | | | | | | | |
| 2.1 | | Зорилт 2.1. Нийслэлийн төсвийн бус санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.<br>НХТЖҮЧ-4.1.1<br>НЗДҮАХ-3.1.1.3<br>ДЗДҮАХ-2.1.2, 2.1.4, 2.1.5 | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90 | 90 ба түүнээс дээш | Нийслэл, дүүргийн өмчийг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн, аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлж, өөрийн орлогыг нэмэгдүүлэн төсөвт төвлөрөх орлогыг 4,3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.<br>Газрын төлбөр өссөн дүнгээр 24.6 сая, Үл хөдлөх хөрөнгийн албан татварт 13,6 сая төгрөг төвлөрүүлэв.<br>2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар:<br>- Улсын төсвийн орлого өссөн дүнгээр 985,2 сая төгрөг | 80 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төвлөрүүлэхээс 887,4 сая төгрөг төвлөрүүлж 90.0 хувьтай,<br>- Нийслэлийн төсөвт өссөн дүнгээр 87,2 сая төгрөг төвлөрүүлэхээс 83,9 сая төгрөг буюу төлөвлөгөөний биелэлт 96,2 хувьтай,<br>- Дүүргийн төсөвт өссөн дүнгээр 884,4 сая төгрөг төвлөрүүлэхээс 1.264,3 сая төгрөг төвлөрүүлж 143.0 хувьтай тус тус биелсэн байна. | | |
| 15. | 2.1.1 | Арга хэмжээ:<br>Нийслэл, дүүргийн өмчийг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн, аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлж, төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ. | - | Түрээсийн орлого, сая төгрөг | 39.8 саятөгрөг | 23.8 сая төгрөг | Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь нийслэл, дүүргийн өмчийн байрыг 4 аж ахуйн нэгжид зах зээлийн бодит үнэлгээг үндэслэн түрээслүүлж, төсөвт 3,3 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор Худалдан авах ажиллагааны алба 0,12 сая төгрөг, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв 0,26 сая төгрөг, Соёлын ордон 4,0 сая төгрөг нийт 7,7 сая төгрөг төвлөрүүлэв. | 80 | 90 |
| 16. | 2.1.2 | Арга хэмжээ:<br>Нийслэл, дүүргийн хэмжээнд газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг сайжруулж, татварт хамрагдалтыг нэмэгдүүлэх, | - | Төсөвт төвлөрүүлэх газар, үл хөдлөх эд хөрөнгийн орлого, сая төгрөг | Газрын төлбөрт 101.3 сая, үл хөдлөх эд хөрөнгийн татварт 190.8 сая төгрөг | Газрын төлбөрт 16,2 сая, үл хөдлөх эд хөрөнгийн татварт 145.9 сая төгрөг | 2025 оны 05 дугээр сарын 31-ний өдрийн байдлаар Газрын төлбөр өссөн дүнгээр 12,2 сая төгрөг төвлөрүүлэхээс 30,9 сая төгрөг буюу 253.2 хувьтай, Үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөвлөгөөгөөр 84 сая төгрөг төвлөрүүлэхээс 13.6 сая төгрөг төвлөрүүлж гүйцэтгэл 16,2 хувьтай биелсэн байна. | 70 | 70 |
| 17. | 2.1.3 | Арга хэмжээ:<br>Улс, нийслэл, дүүргийн татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх | - | Төсөвт төвлөрүүлэх орлого, сая төгрөг | Улсын төсвийн орлого 2,010.2 сая | Төлөвлөгөөний дагуу татварын орлогыг бүрдүүлсэн байна | 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар:<br>- Улсын төсвийн орлого өссөн дүнгээр 985,2 сая төгрөг төвлөрүүлэхээс 887,4 сая төгрөг төвлөрүүлж 90,0 хувьтай, | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төгрөг, Нийслэлийн төсвийн орлого 66.5 сая төгрөг, Орон нутгийн төсвийн орлого 2,794.6 сая төгрөг, Нийт татварын орлого 4,871.3 сая төгрөг | | - Нийслэлийн төсөвт өссөн дүнгээр 87,2 сая төгрөг төвлөрүүлэхээс 83,9 сая төгрөг буюу төлөвлөгөөний биелэлт 96,2 хувьтай,<br>- Дүүргийн төсөвт өссөн дүнгээр 887,4 сая төгрөг төвлөрүүлэхээс 1.264,3 сая төгрөг төвлөрүүлж 115.8 хувьтай тус тус биелсэн байна. | | |
| 2.2 | | Зорилт 2.2<br>Орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийг иргэдэд нээлттэй мэдээлэх, иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.<br>НЗДҮАХ-ХАХТ-4.1.1.2<br>ДЗДҮАХ 2.1.1 | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90 | 90 ба түүнээс дээш хувь | Орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийг дүүргийн цахим хуудас, бусад мэдээллийн сувгуудаар иргэдэд нээлттэй ил тод мэдээлэн иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн ажиллав. | 80 | 70 |
| 18. | 2.2.1 | Арга хэмжээ:<br>Орон нутгийн сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг иргэдээс цахим хэлбэрээр буюу гар утасны аппликейшн | - | Цахимаар санал өгсөн иргэд, хувь | 68% | 80% | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих төсөл хөтөлбөр арга хэмжээний саналд 4 ажлын саналыг хүргүүлээд байна.<br>Нийслэл болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга | 30 | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ашиглан авах. | | | | | хэмжээнд иргэдээс цахим санал, асуулга авах ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулав. 2025 оны 06 дугаар сарын 2-ны өдрийн байдлаар цахим санал асуулгад 441 иргэн санал өгч хамрагдалт 16%-тай байна.<br>2026 онд дараах ажлыг хэрэгжүүлэхээр иргэдээс санал авсан. Үүнд:<br>- Үерийн далан суваг шуудуу засаварлах,<br>- Гэр хороолол болон шинэ суурьшлын бүсэд цахилгаан хангамж нэмэгдүүлэх,<br>- Тохижилт, засвар үйлчилгээ,<br>- Гэрэлтүүлэг,<br>- Автомашины зогсоол байгуулах,<br>- Камержуулалт,<br>- 1, 2 дугаар хороог холбосон ногоон байгууламж нэмэгдүүлэх зэрэг болно. | | |
| 19. | 2.2.2 | Арга хэмжээ:<br>Үнэлгээний хороонд иргэдийн төлөөллийг томилох, хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлын явцад хяналт тавих комиссын бүрэлдэхүүнд иргэдийн төлөөллийг оруулж оролцоог нэмэгдүүлэх | - | Үнэлгээний хороо болон Комиссын бүрэлдэхүүнд орсон иргэдийн тоо, хувь | Давхар дсан тоогоор 39 иргэн | 15 иргэн | Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 23 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөн.<br>23 Үнэлгээний хороог хууль, журмын дагуу байгуулж, давхардсан тоогоор 115 албан хаагч, иргэн ажиллав. Үнэлгээний хорооны гишүүдээр “Ашиг сонирхолын мэдүүлэг” бөглүүлэн shilendans.gov.mn, tender.gov.mn болон бусад мэдээллийн сувгуудаар ил тод нээлттэй мэдээллэж байна.<br>2025 оны эхний хагас жилийн байдлаар цахим системээр зарласан 16 ажил, шууд худалдан авсан 7 ажил төсөл арга хэмжээ байна. Цахим системээр зохион байгуулсан 16 ажлын тендер шалгаруулалтын үр дүнг хуулийн | 100 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хугацаанд байршуулж иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлсэн. ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу А3 гэрчилгээтэй сургалтад 4 албан хаагчийг хамруулав. | | |
| 20. | 2.2.3 | Арга хэмжээ: 2024 онд хэрэгжиж дууссан, он дамжин хэрэгжиж буй ажлууд болон 2025 онд хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын талаар танилцуулга, гарын авлага бэлтгэж иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах. | | Гарын авлагын тоо, хувь | 150 ширхэг гарын авлага | 150 ширхэг гарын авлага | Улс, нийслэл, ОНХС, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 34 төсөл хөтөлбөр, арга хэмжээний талаар товхимол гарган 1, 2 дугаар хороодоор дамжуулан иргэдэд хүргэв. Мөн 100 ширхэг календарь гарган төсвийн байгууллагын албан хаагчдад тараасан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журам, заавар шинэчлэн батлагдсантай холбогдуулан дүүргийн удирдах ажилтаны шуурхай зөвлөгөөнд 1 удаа танилцуулга хийв. | 100 | 100 |
| 2.3 | | Зорилт 2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож, үр дүнтэй зарцуулах. ДЗДҮАХ-2.1.1 | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 90 | 90 ба түүнээс дээш хувь | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан 23 ажлаас 16 ажлыг холбогдох журмын дагуу цахим системээр зохион байгуулж, тендер шалгаруулалтын үр дүнг /tender.gov.mn/ цахим системд ил тод нийтлэв. | 95 | 90 |
| 21. | 2.3.1 | Арга хэмжээ: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг холбогдох журмын дагуу 100 хувь цахим | - | Хөрөнгө оруулалтын ажлын тоо, хувь | 38 ажил | 15 ажил | Төрийн Худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуулийн хугацаанд шивж баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажиллав. Дүүргийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сан, Нийслэлийн | 100 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | системээр зохион байгуулж, тендер шалгаруулалтын үр дүнг /tender.gov.mn/ цахим системд ил тод нийтэлсэн байх. | | | | | Засаг даргаас эрх шилжин ирсэн ажлын тендер шалгаруулалтад ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу нийт 41 компани оролцсон. Үүнээс тендерт шалгарсан мэдэгдлийг 22 компанид, шалгараагүй мэдэгдлийг 19 компанид хүргүүлсэн бөгөөд шилэн дансанд оролцогч компаниудын мэдээллийг байршуулсан.<br>Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 23 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс 2025 оны эхний хагас жилийн байдлаар цахим системээр зарласан 16 ажил, шууд худалдан авсан 7 ажил төсөл арга хэмжээ байна. Цахим системээр зохион байгуулсан 16 ажлын тендер шалгаруулалтын үр дүнг хуулийн хугацаанд tender.gov.mn, shilendans.gov.mn сайтад тухай бүр байршуулан байршуулж иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлсэн. | | |
| 22. | 2.3.2 | Арга хэмжээ:<br>Дүүргийн орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажлын төлөвлөгөө болон улс, нийслэл, ОНХСан, дүүргийн хөрөнгө оруулалтын зарцуулалтыг shilendans.gov.mn сайтад байршуулж иргэдэд нээлттэй мэдээлэх. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% | 100% | Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн тайлан мэдээг хуулийн хугацаанд shilendans.gov.mn сайт болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулж ажиллав.<br>Үүнд:<br>- 2025 оны Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө,<br>- Шилэн дансны тухай бүр цэсэнд 14, сар бүр цэсэнд 14, бүтэн жил цэсэнд 4, нийт 32 мэдээ байршуулав.<br>Зарлан мэдээлэх журмын дагуу нээлттэй тендер шалгаруулалтын журмаар-16, шууд худалдан авалтаар- | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 7, нийт 23 бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг цахим системээр батлуулсан. 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар 23 ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж төлөвлөгөөний биелэлт 56 хувьтай байна. Мөн ОНХС-гийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр арга хэмжээний саналыг гар утасны апплекэйшн, цахимаар хэрхэн санал авах талаар мэдээллийг 4 удаа тус тус мэдээлсэн. | | |
| 2.4 | | Зорилт 2.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан, төсөв, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулах<br>НЗДҮАХ 4.1.4<br>ХАХТ 4.1.4.1<br>ДЗДҮАХ 2.1.6 | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90 | 90 ба түүнээс дээш хувь | Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж төсвийг хэмнэж ажилласнаар 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төсвийн зарлага төлөвлөгөөгөөр 7.368,2 сая төгрөг байхаас гүйцэтгэлээр 4.973,8 сая төгрөгийг зарцуулж, 2.394,7 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллав. | 100 | 90 |
| 23. | 2.4.1 | Арга хэмжээ: Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, төсөв санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлж хэвшүүлнэ. | - | Хэмнэгдсэн төсвийн мөнгөн дүн | 1.038.2 сая төгрөг | Хэрэгжилтийн хувь | Улсын төсвийн 10, Орон нутгийн төсвийн 6, ОНӨААТҮГ-ын 4 байгууллага, дүүргийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны жилийн эцсийн аудитын шалгалтаар баталгаажсан тайланг хүлээн авч нэгтгэв.<br>ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланг гарган Нийслэл дэх Төрийн аудитаар шалгуулан баталгаажуулж, дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Аудитын шалгалтаар “Зөрчилгүй” гэсэн санал дүгнэлтийг авсан.<br>Улсын болон орон нутгийн төсвийн 20 байгууллагын 70 дансны орлого, зарлагын гүйлгээнд Төрийн сангийн төлбөр тооцоогоор дамжуулан хяналт тавин МУЗГ-аас гаргасан төсвийг зөв | 100 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зохистой ашиглах, хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаж байна. 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төсвийн зарлага төлөвлөгөөгөөр 7.368,2 сая төгрөг байхаас гүйцэтгэлээр 4.973,8 сая төгрөгийг зарцуулж, 2.394,7 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллав. | | |
| 2.5 | | **Зорилт 2.5** Бизнесийн орчин буюу үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, жижиг дунд үйлдвэрийг дэмжих, гадаад дотоодын хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлнэ. (АХ-2.4.2, 2.6.3, 4.1.29, 4.5.8, 4.5.9, МУХТЖҮЧ-8.3.10, ЗГҮАХ-1.2.1.3, 3.3.1.8, 2.1.3.12, 2.1.3.13, НХТЖҮЧ-4.3.3, НЗДҮАХ-3.3.1, 3.3.2, 3.3.8, 3.3.9, ДЗДҮАХ 2.2.1, 2.2.2, 2.2.3, 2.2.4, 2.2.5 | 43,6 | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100% | 100% | “Нар харах ёслол” арга хэмжээнд “MJ” брэндийн шинэхэн бүтээлүүдийг иргэдэд толилуулж, худалдаа үйлчилгээ зохион байгуулсан. Мөн малчин телевизээс дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн байранд үйл ажиллагаа явуулдаг бичил бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг сурталчилсан нэвтрүүлэг бэлтгэн тус телевизээр иргэд олон нийтэд хүргэсэн. | 70 | 70 |
| 24. | 2.5.1 | Арга хэмжээ: Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээнд инноваци, шинэ технологи нэвтрүүлэх замаар баялаг бүтээх цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэн гарааны бизнесийг дэмжинэ. | - | Зохион байгуулах ажил/ хамрагдсан иргэний тоо | 13/39 | 9/20 | 2025.01.01-ний өдрийн “Нар харах ёслол” арга хэмжээнд MJ брэндийн шинэхэн бүтээлүүдийг иргэдэд толилуулж, худалдаа үйлчилгээ зохион байгуулсан. Мөн Малчин телевизээс дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн байранд үйл ажиллагаа явуулдаг бичил бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг сурталчилсан нэвтрүүлэг бэлтгэн тус телевизээр иргэн олон нийтэд хүргэсэн. | 70 | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6 | | **Зорилт 2.6** Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлж, мал сүргийг эрүүлжүүлэн хүнсний аюулгүй байдлыг хангана. (АХ-8.3.17, 8.3.12, 8.3.18, МУХТЖҮЧ-3.3.5, 8.3.7, ЗГҮАХ-3.3.4.31, НЗДҮАХ-3.5.10, 3.5.11, ДЗДҮАХ 2.3.1, 2.3.2, 2.3.3, 2.3.4 | | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100% | 100% | “Шинэ хоршоо” хөдөлгөөн хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан дүүргийн малчин болон мал бүхий өрхийн 25 иргэнд хоршооны талаарх мэдээллийг хүргэн ажилласан. | 50 | 30 |
| 25. | 2.6.1 | Арга хэмжээ: Малыг эрүүлжүүлэх, чанар, үүлдэр угсааг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйг дэмжиж малчдыг нэгтгэн “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг өрнүүлнэ. | 21,0 | Зохион байгуулах ажлын тоо | 14 удаа | 10 удаа | “Шинэ хоршоо” хөдөлгөөн хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан дүүргийн малчин болон мал бүхий өрхийн 25 иргэнд хоршооны талаарх мэдээллийг хүргэн ажилласан.<br>Уг хөдөлгөөний хүрээнд дүүрэгт “Хангай мэргэн” хоршоо 2024 онд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.<br>2025 онд шинэ хоршоо байгуулах хүсэлтэй 1 өрх байгаа боловч хамтарч оролцох малчин өрх одоогоор байхгүй байна. | 50 | 30 |
| 2.7 | | **Зорилт 2.7** Орон нутгийн брэнд, аялал жуулчлалыг хөгжүүлнэ. (АХ-1.1.1, 1.2.10, 2.6.10, 3.3.1, 4.2.43, МУХТЖҮЧ-6.2, ЗГҮАХ-3.4.2, НЗДҮАХ-3.4.2, 3.4.3, ДЗДҮАХ 2.4.1, 2.4.4, ЗДТГАХ-2.7.1) | 4,7 | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100% | 100% | 2025.01.01-ний өдөр “Нар харах” арга хэмжээг зохион байгуулан 5000 орчим иргэд цугласнаас 100 орчим гадаадын жуулчид хүрэлцэн ирсэн байна. | 75 | 30 |
| 26. | 2.7.1 | Арга хэмжээ: Шинэ оны анхны нар угтах ёслол зохион байгуулна. | 4.2 | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100% | 100% | Дүүргийн Засаг даргын 2024.12.18-ны өдрийн А/217 дугаар захирамжаар “Шинэ оны анхны нар угтах” ёслолын арга хэмжээг зохион байгуулах ажлын | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэсэг"-ийг байгуулсан. Нар харах арга хэмжээг 2025.01.01-ний өдөр амжилттай зохион байгуулж нийт 1000 гаруй тээврийн хэрэгсэл цугларч, 5000 орчим хүн хүрэлцэн ирснээс 100 орчим гадаадын жуулчид ирж оролцсон байна. Мөн хүрэлцэн ирсэн иргэдэд дүүргийн жижиг, дунд бизнес эрхлэгч иргэд халуун хоол цайгаар үйлчлэх, худалдаа үйлчилгээ явуулах, морь унуулах үйлчилгээ үзүүлэн 380,000 төгрөгийн борлуулалт хийж, галын наадам, урлагийн тоглолт үзүүлэх ажлыг зохион байгуулав. Хүрэлцэн ирсэн иргэдэд дүүргийн танилцуулга бүхий тараах материалыг бэлтгэж 70 иргэнд тараан ажиллалаа.<br>Уг үйл ажиллагаанд дүүргийн Засаг даргын Нөөц хөрөнгөөс 2,5 сая төгрөг зарцуулав. | | |
| 27. | 2.7.2 | Арга хэмжээ:<br>Дүүрэгт худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн гудамжийг бий болгож, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллана. | - | Тоо хэмжээ | - | 1 | *Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалын эргэлтэд оруулж тохижуулах боломжтой 2 байршлын (Аялал жуулчлалын эргэлтэд оруулж тохижуулах боломжтой газар-дүүргийн өндөрлөг, явуулын худалдаа үйлчилгээ бий болгох боломжтой газар-төв талбайн зүүн талын "Гэрэлт гудамж") –ны талаарх мэдээллийг 2025.03.25-ны өдөр Нийслэлийн аялал жуулчлалын газарт хүргүүлсэн.*<br>*Мөн дүүргийн зүгээс Шинэ оны нар харах байршилд Нарны тойром, Шагайн харваа зохион байгуулахаар төлөвлөн энэ хүрээнд жижиг дунд бизнес эрхлэгч болон худалдаа үйлчилгээний орлогыг нэмэгдүүлэх зорилгоор тойром болох газар* | 50 | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | *худалдаа гаргаж ажиллахаар төлөвлөж байна.* | | |
| ***ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО*** | | | | | | | | | |
| ***3.1 Иргэдийн оролцоог хангасан, авлигаас ангид, үр нөлөөтэй, цахимжсан, хариуцлагатай, мэргэшсэн тогтвортой засаглалтыг төлөвшүүлэх / /НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗААЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД (4 зорилт 27 арга хэмжээ)*** | | | | | | | | | |
| 3.1. | | **Зорилт 3.1.** Хүний нөөцийн тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх, хариуцлагатай, мэргэшсэн төрийн албан хаагчдыг бүрдүүлнэ НЗДҮАХ 5.1.2, 5.1.10-5.1.16, 5.2.2, 5.2.7, 5.4.4, 5.5.1, НХТЖҮЧ 5.1.1, 5.1.2, 5.3.1, 5.3.2, 7.3.2, ДЗДҮАХ 3.1.1- 3.1.10, 3.2.2., 3.1 | - | Сул орон тоо нөхөх ажлын байрны тоо | 5 | 5 ба түүнээс дээш | ***Хүний нөөцийн мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд дүүргийн https://www.bagakhangai.ub.gov.mn/home веб сайтад тухай бүр сул орон тооны зарыг байршуулан ажиллалаа. Төрийн албаны зөвлөлд тусгай шалгалтын захиалгыг 1 удаа хүргүүлж тусгай шалгалтад нийт 3 албан хаагч бүртгүүлсэн бөгөөд боловсролын индекс, мэргэжил тааруулгүй тул материал цуцлагдсан байна.*** | 85 | 90 |
| 28. | 3.1.1 | Арга хэмжээ: Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг дээшлүүлэн, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлнэ | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 89% | 90 ба түүнээс дээш хувь | *Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, чадавхжуулах, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллахад бодитой дэмжлэг үзүүлэх зорилгоор дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2025 оны А/06 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг батлуулсан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөг дүүргийн Засаг даргын 2025 оны А/84 дүгээр захирамжаар хэрэгжүүлэх 12 арга хэмжээтэйгээр батлуулан, төлөвлөгөөг аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлээд байна. 2025 оны хагас жилийн хэрэгжилтийн тайланг нэгтгэхээр 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор* | 90 | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | *биелэлт ирүүлэх тухай Засаг даргын Тамгын газрын 04/348 дугаар албан бичгийг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нийт 28 ААНБ-д хүргүүлээд байна.*<br>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын хүрээнд нийт 54 албан хаагчийн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоов.<br>Төрийн тусгай албан хаагчдын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг 2 албан хаагч, Төрийн албан хаагчийн нэмэгдлийг 1 албан хаагч, Төрийн албаны тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд заасны дагуу 6 албан хаагч, Төрийн захиргааны албан тушаалд тасралтгүй 5 жил болон түүнээс дээш хугацаанд ажилласан албан хаагчид 6 сарын үндсэн цалинтай тэмцэх хэмжээний мөнгөн урамшууллыг 1 албан хаагч нийт 15 албан хаагчдад нэмэгдэл урамшууллыг олгон ажиллалаа.Мөн төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт заасны дагуу 3 албан хаагчийг шилжүүлэн ажилласан байна. | | |
| 29. | 3.1.2 | Арга хэмжээ:<br>Төрийн албан хаагчдын ур чадварыг хөгжүүлэх, хэрэгцээ шаардлагын тодорхойлно | - | Судалгаа/ тоо | - | 2 | Албан хаагчдыг хөгжүүлэх, ур чадварыг дээшлүүлэх ажлын хүрээнд Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2025 оны А/06 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг батлуулсан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөг дүүргийн Засаг даргын 2025 оны А/84 дүгээр захирамжаар хэрэгжүүлэх 12 арга хэмжээтэйгээр батлуулсан. 2025 онд нийт 24 удаагийн сургалтад давхардсан тоогоор 200 албан | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хаагчийг хамруулан мэдлэг чадварыг дээшлүүлснээс Төрийн албаны зөвлөл, нийслэлийн ЗДТГ-аас зохион байгуулсан Төрийн албаны тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар, Төрийн албан хаагчийн ёс зүй сургалтад давхардсан тоогоор 120 албан хаагч, Төрийн цахим үйлчилгээ зохицуулалтын газраас зохион байгуулсан “Их өгөгдөл, хиймэл оюун ухаан” анхдугаар чуулганд 6 албан хаагч, орон нутгийн ААНБ-аас зохион байгуулсан харилцаа хандлага, хууль, эрх зүйн сургалт мэдээлэл, арга хэмжээнд давхардсан тоогоор 74 албан хаагч хамрагдсан байна. Мөн улсын төсвийн зардлаар Удирдлагын академийн төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2 албан хаагч, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 5 албан хаагч, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч нийт 9 албан хаагч, Архивын ерөнхий газраас 2025 онд зохион байгуулах архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудын сургалтад 2 албан хаагчийг тус тус хамруулан 500,000 мян.төг холбогдох төсвөөс гаргуулан ажиллалаа. Мөн төрийн албан хаагчийн гүйцэтгэлийг үнэлэхдээ хандлага ёс зүй, ур чадвар, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байдлыг шалгуур болгон ажиллаж байна. | | |
| 30. | 3.1.3 | Арга хэмжээ: Хууль, эрх зүйн шинэчлэлийг үргэлжлүүлэх эрх зүйн сургалт, сурталчилгаа, | - | Сургалтын тоо, хамрагдсан иргэдийн тоо | 27/653 иргэн | 20 /700 иргэн | Дүүргийн Засаг даргын 2025 оны А/60 дугаар захирамжаар Дүүргийн Хууль, эрх зүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх 25 арга | 85 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зөвлөгөө, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлнэ | | | | | хэмжээтэйгээр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлт 84%-тай байна. Тус ажлын хүрээнд холбогдох дээд шатны байгууллага болон дүүргийн ААНБ-тай хамтран танхимын сургалт 14, цахим сургалт 5 удаа зохион байгуулан нийт 712 иргэд, албан хаагчдыг хамруулан эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлсэн байна. | | |
| 31. | 3.1.4 | Арга хэмжээ:<br>Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлнэ | - | Зохион байгуулах сургалт, гарын авлагын тоо | 7<br>130 ш | 5 доошгүй<br>200 ш | Хүнд суртлыг багасгах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дүүргийн үйл ажиллагаагаа сурталчлах "Нээлттэй хаалга"-ны өдөрлөг арга хэмжээнд олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллага, ААНБ-ын хүлээх үүрэг, хориглох зүйл", "Авлигын тухай болон албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх", "Нийтийн албан тушаалтан, Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах албан тушаалтны тухай ойлголт, анхаарах асуудал" 3 төрлийн гарын авлага бэлтгэн 34ш, Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлах 9 төрлийн гарын авлага 24ш, плакат 13ш, стейкэр 36ш иргэдэд тарааж зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллав. Өдөрлөгийн үеэр "Авлигын индекс ба шударга байдлын үнэлгээг нэмэгдүүлэх" чиглэлээр санал асуулга бэлтгэн иргэдээс авч ажиллалаа.<br>Мөн "Авлигын тухай мэдэгдэх", "Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх" тухай 2 төрлийн видео | 85 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | контент бэлтгэн дүүргийн bagakhangai.ub.gov.mn веб сайт, байгууллагын фейсбүүк хуудсуудаар сурталчлан ажиллалаа.<br>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "ХАСХОМ, ХАСУМ-ийг бүртгэх, хянах, хадгалах, ХАСХОМ гаргах эрх албан тушаалтны жагсаалт гаргах, тайлагнах, мэдэгдэл, тайлбар гаргах" сургалт 2, "2024 оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг шинэчлэн гаргах", "Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийн тухай ойлголт" цахим сургалтуудыг зохион байгуулан 6 ЭБАТ, 54 ХАСХОМ гаргах албан тушаалтан 141 төрийн болон үйлчилгээний албан хаагчдыг хамрууллаа. | | |
| 32. | 3.1.5 | Арга хэмжээ:<br>MNS ISO 9001 чанарын менежментийн тогтолцооны стандартыг баталгаажуулж нэвтрүүлнэ | - | Стандартыг нэвтрүүлсэн байгууллага, стандартын тоо | - | 1 /1 | Орон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, менежментийн сайн түвшинд хүрэх, сайн засаглалыг бий болгох, төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор "Менежмент ба ур чадварын хүрээлэн" ТББ, "Глобал Куалити" ХХК хамтран ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлж 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Засаг даргын Тамгын газарт Олон Улсын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлж "Менежмент ба ур чадварын хүрээлэн" ТББ-ын Захирал Т.Мөнгөнбөгжөөс баталгаажилтын гэрчилгээгээ гардан авлаа. | 90 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 33. | 3.1.6 | Арга хэмжээ: “Багахангай 2040 хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | - | 90 ба түүнээс дээш | Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь судалгаа, зөвлөх үйлчилгээний “Эс Ай Си Эй” ХХК-тай 2023 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан гэрээний дагуу “Багахангай 2040 хөгжлийн хөтөлбөр” бодлогын баримт бичгийг гүйцэтгүүлж, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын ээлжит XXV хуралдаанаар хэлэлцүүлэн, 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын А/06 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Дээрх тогтоолын 2.3 дахь хэсэгт “Багахангай 2040 хөгжлийн хөтөлбөр” бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд 2 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулахаар тусгагдсан.<br>Энэ хүрээнд 2025 оноос эхлэн улс, нийслэл, дүүргийн хэмжээний хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан хэрэгжилтийг эрчимжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.<br>“Багахангай 2040 хөгжлийн хөтөлбөр” бодлогын баримт бичгийг гүйцэтгэгч компани нь баримт бичгийг 2025-2030, 2031-2040 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 116 арга хэмжээг мөн төлөвлөсөн.<br>Тус бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөг дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээтэй уялдуулан хэрэгжилтийг ханган ажиллахаар төлөвлөөд байна. | 50 | 30 |
| 34. | 3.1.7 | Арга хэмжээ: | - | Тайлан | 11 | 11 баримт | Монгол Улсын хөгжлийн урт, дунд | 90 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн чанарыг үр дүнг дээшлүүлнэ | | биелэлтийн тоо, дундаж хувь | баримт бичиг 92% | бичиг 90 түүнээс дээш хувь | хугацааны бодлогын баримт бичгүүд болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн чанар, үр дүнг дээшлүүлэх хүрээнд дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудаас тайлан биелэлтийг авахдаа нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6 дахь хэсэгт заасан дараах шаардлагын дагуу тайлагнахыг анхааруулан ажиллаж хэвшээд байна. | | |
| 35. | 3.1.8 | Арга хэмжээ:<br>Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ | - | Төрийн үйлчилгээний төрөл, иргэдийн тоо | 51/76 | 51/80 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Засаг даргын Тамгын газартай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн хүртээмжийг сайжруулах зорилгоор тусгай хэрэгцээт төрийн цахим үйлчилгээний КИОСК машиныг 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн Засаг даргын Тамгын газарт байршуулж төрийн үйлчилгээг нэг дороос үзүүлж тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 24 төрлийн үйлчилгээг 32 иргэн аваад байна.<br>“Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, олон нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх (demosc)” төслийн хүрээнд Цахим хөгжил, инновац, Харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас тус дүүрэгт 2025 оны 5-р сарын 5-ны өдөр нийт 130 гаруй төрийн албан хаагчдад болон иргэдэд “Мэдээллийн аюулгүй байдал, цахим ур чадварыг нэмэгдүүлэх | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалт"-ыг зохион байгууллаа. Мөн хөдөлгөөнт хурдан цэгийн үйлчилгээ дүүргийн 2-р хорооны "Бор үзүүрт" байрлан 13 иргэнд үйлчилгээ үзүүлж ажиллалаа. | | |
| 36. | 3.1.9 | Арга хэмжээ:<br>Гадаад улс орон, найрамдалт харилцаат хотуудтай харилцан ашигтай хамтын ажиллагаа тогтоох, харилцан туршлага солилцоно | - | Туршлага судалсан албан хаагчийн тоо | 8 байгууллага20 албан хаагч | 10-оос доошгүй албан хаагч | Дүүргийн гадаад харилцааг өргөжүүлэх ажлын хүрээнд нийт 17 байгууллагын 27 албан хаагч БНХАУ, БНСУ-д улсад албан томилолтоор ажиллан, эрүүл мэнд, спорт, үйлдвэрлэл, хог хаягдал, онцгой байдлын салбарын үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцов. Мөн БНСУ-ын Пусан хотын Кижан аймагтай хамтран ажиллах санамж бичиг байгуулахаар төслийг боловсруулан, тус аймгийн удирдлагуудыг дүүрэгт урьж, айлчлалын бэлтгэл ажлыг хангаж байна. | 90 | 90 |
| 37. | 3.1.10 | Арга хэмжээ:<br>Өргөдөл, гомдлын зөрчлийн тоог бууруулах, шийдвэрлэлтэд хяналт тавина | - | Өргөдөл, гомдлын зөрчлийн тоо, | 76 зөрчил | Зөрчилийн тоог 20-иос ихгүй | 2025 оны хагас жилийн байдлаар иргэдээс дүүргийн нутгийн захиргааны 14 байгууллагад нийт 120 өргөдөл ирснээс 114 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 6 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна. Иргэдээс ирүүлсэн 7 гомдлыг бүрэн барагдуулж, иргэнд албан бичгээр хариуг хүргүүлэн ажиллалаа.<br>Иргэдээс ирүүлсэн өргөдөлд хууль зүйн үндэслэлийг тусган, 20 өргөдлийн хариуг иргэнд албан бичгээр, 70 өргөдлийн хариуг иргэнд биечлэн хүргэж, 24 өргөдлийн хариуг утсаар өгч ажиллалаа. Иргэний талд шийдвэрлэсэн 88 өргөдөл, боломжгүй хариу өгсөн 25 өргөдөл байна. | 90 | 90 |
| 38. | 3.1.11 | Арга хэмжээ: | - | Арга хэмжээ | 3 | 3 | Тайлангийн хугацаанд "Улаанбаатар | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ | | тоо Иргэдийн тоо | 459-аас доошгүй | 500-аас доошгүй | хот-2040” хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг иргэдэд танилцуулах уулзалт, УИХ-ын гишүүний уулзалт, ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх "Ахмадаа сонсъё" арга хэмжээ, их дээд сургуульд суралцаж буй оюутан залуусийн уулзалт, “Иргэн таныг сонсъё” өдөрлөг, нийт иргэдтэй хийх уулзалтыг 5 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 45 аж ахуйн нэгж, байгууллагын 574 иргэн, албан хаагчтай уулзаж, санал хүсэлтийг сонсон, холбогдох тайлбар, мэдээллийг өгч ажиллалаа. | | |
| 39. | 3.1.12 | Арга хэмжээ: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлнэ | - | Байршуулсан захирамжлалын баримт бичиг, тоо | 195 захирамж 65 тушаал | 200-аас доошгүй | Тайлангийн хугацаанд дүүргийн веб сайтад 101 захирамж, ublegal.ulaanbaatar.mn сайтад А/106, Б/10 захирамж байршуулсан байна. Засаг даргын Тамгын газрын даргын 23 тушаалыг шилэн дансанд байршуулав. | 90 | 90 |
